

Аудитын код: САГ-2018/14/СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Аудитор Д.Цэгмиддорж
Утас: 261740 Цахим хаяг: tsegmiddorjd@audit.gov.mn

Улаанбаатар хот

АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	0
2	Аудитын тайлан.....	1
2.1	Оршил	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	2
2.5	Дотоод хяналт	3
2.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	3
2.7	Шилэн дансны мэдээлэл	4
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	4
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	4
2.9.1	Аудитын санал дүгнэлтийн талаар	5
2.9.2	Түүвэрт хамрагдсан, Зөрчилгүй, Хязгаарлалттай, Сөрөг санал дүгнэлт авсан байгууллагад илэрсэн зөрчлийн талаар	5
2.9.3	Бараа материалын талаар.....	5
2.9.4	Мөнгөн хөрөнгийн талаар	5
2.9.5	Үндсэн хөрөнгийн талаар.....	6
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	6
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	6
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	6
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	6
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	7
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
2.16	Аудитаар тооцсон үр өгөөж	7
3	Менежментийн захидал	8
3.1	Акт, албан шаардлага, зөвлөмжийн талаар	9
3.2	Бараа материалын талаар	10
3.3	Мөнгөн хөрөнгийн талаар.....	11
3.4	Үндсэн хөрөнгийн талаар.....	12
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	13
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	13
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	14
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан.....	15
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан.....	16
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17
5	Зөрчлийн нэгтгэл	19



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2018.03.23 № 01/796
танай _____ -ны № _____ -т

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН
ДАРГА Ц.ГАНХҮҮ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_Kheregl\Yawsan_Bichig\2018\0323SAG17.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ОЮУНБИЛЭГ

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2018\0323SAG17.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 Оршил

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга Ц.Ганхүү танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах, зардлыг төсөвлөх, авлагыг тооцоо нийлж баталгаажуулах, үндсэн үйл ажиллагааны орлогыг бүрэн тайлагнах, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.


Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитыг 2018 оны 3 дугаар сарын 05-наас 2018 оны 3 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын САГ-ын Аудитор Д.Цэгмиддорж гэрээт аудитор Н.Сүнжидмаа нар хэрэгжүүлж ажиллав.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг 2018 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 1/367 дугаартай албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.



2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Монгол Улсын Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388, 2008 оны 352 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”-ыг ашиглаж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуульд өөрчлөлт ороогүй байна.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын эрхэм зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд геодези, зураг зүй, газар зохион байгуулалт, газрын кадастр, барилга, хот байгуулалтын салбарын шинжлэх ухаан, технологийн талаарх бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, иргэдийн амьдрах болон баялаг бүтээх эрхийг хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэхэд оршино.

Үйл ажиллагааны стратегийн зорилт

- Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд геодезийн бүх төрлийн сүлжээ, байр зүйн болон сэдэвчилсэн тоон зураглалын тогтолцоог байгуулж, хэрэглээг арга зүйгээр хангах;
- Монгол Улсын нутаг дэвсгэр дэх усны сав газар бүрээр геологи болон хүрээлэн буй орчны иж бүрэн мэдээллийн санг хэрэглэгчидтэй хамтран байгуулах, бусад салбаруудтай хамтран газрын төлөв байдал, чанарын мониторингийн сүлжээ байгуулж нэгдсэн инженерийн дүгнэлт гаргах, газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа, нөхөн сэргээлт хийх;
- Нийт нутаг дэвсгэр дээрх эдлэн газар, үл хөдлөх хөрөнгө, нөхцөл байдал, үйл ажиллагааг төрийн өмнөөс кадастрын хэмжилт, зураглал, хаягжилт, бүртгэлээр баталгаажуулах, байрлал бүхий үл хөдлөх хөрөнгийн иж бүрэн мэдээллийн сан, хувийн хэрэг, газрын бирж, үнийн мэдээ, үнэлгээ, төлбөр, татварын тогтолцоог байгуулж, төрийн нэрийн өмнөөс хэрэглэгчийг баталгаат мэдээллээр хангах;
- Геодези, зураг зүйн суурь бүхий геологи, хүрээлэн буй орчин, газар ашиглалтын төлөвлөлт, түүний зохион байгуулалт, газрын кадастрын мэдээллийг өгөгдлийн сангийн нэгдсэн стандартын дагуу нэгтгэн боловсруулах, дүн шинжилгээ хийх, удирдан зохион байгуулж Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийг байгуулах, мэдээллийг хадгалах, хамгаалах, уялдаа холбоог сайжруулах, хэрэглэгчдэд түгээх, мэдээллийн ил тод байдлыг хангах;
- Хүн амын нутагшилт суурьшил, нийгэм, эдийн засаг, дэд бүтэц, геологи, гидрогеологи, хүрээлэн буй орчны мэдээлэлд суурилсан нутаг дэвсгэрийн зохион байгуулалт, бүс нутаг, хот суурины хөгжлийн хандлагад нийцсэн хот төлөвлөлтийн арга зүйгээр хангах, хот байгуулалтын кадастр эрхлэх, нэгдсэн мэдээллийн сан байгуулах, хяналт тавих, хэрэгжилтийг зохион байгуулах;
- Барилга, хот байгуулалтын салбарын шинжлэх ухаан, техник технологийн бодлогыг хэрэгжүүлэх, норм, нормативын санг бүрдүүлэх, зарцуулах үйл ажиллагааг зохион байгуулах, зөвлөх үйлчилгээ, салбарын ажилтан, хуулийн этгээдийн нэгдсэн бүртгэл хөтлөх, мэдээллийн сан бүрдүүлж, мэдээ, мэдээллээр хангах;

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000–1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн гол шалгуур болголоо.

Аудитаар Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан

нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Гүйцэтгэлийн шатанд санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан 22 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Материаллаг байдлын түвшингийн суурийг тус байгууллагын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 2 хувиар тооцож 666.0 сая төгрөгөөр тогтоосон болно. /ТАБ-СТА-В1/

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг “Acolous” програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлан бодох үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

2017 онд тус газрын санхүүгийн үйл ажиллагаанд Барилга хот байгуулалтын яамны хяналт шинжилгээ, дотоод аудитын хэлтсээс хяналт шалгалт орсон байна. Мөн аймаг нийслэлийн харьяа газруудад 2017 оны А/195 дугаар тушаалаар хяналт шинжилгээ хийж, илэрсэн алдаа зөрчлийг арилгах цаашид хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган ажилласан байна.

2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу салбарын яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулан, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангаж, төсвийг зардлын зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

/сая төгрөгөөр/

Д/д	Аймгийн нэр	Орлогын төлөвлөгөө		Орлогын гүйцэтгэл		Нийт орлогын төлөвлөгөө	Нийт орлогын гүйцэтгэл	Зөрүү
		Барилга техник хяналт	Газрын хуульд заасан хэлбэрээр ашиглах, эзэмших	Барилга техник хяналт	Газрын хуульд заасан хэлбэрээр ашиглах, эзэмших			
1	Говьсүмбэр	15.0	15.0	14.0	8.6	30.0	22.6	(7.4)
2	Дархан-Уул	30.0	15.0	17.8	21.4	45.0	39.2	(5.8)
3	Төв	39.0	20.0		35.0	59.0	35.0	(24.0)
4	Увс	42.0	14.4	22.7	13.9	56.4	36.6	(19.8)
5	Хөвсгөл	35.0	20.0		24.9	55.0	24.9	(30.1)
6	ГХГЗЗГ		118.5		90.2	118.5	90.2	(28.3)
НИЙТ		161.0	84.4	54.5	103.8	245.4	158.3	(87.1)

01

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Нийт 1,765.3 сая төгрөгийн орлогын төлөвлөгөө батлагдсанаас гүйцэтгэлээр 1,843.8 сая төгрөг буюу 78.5 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Нэр бүхий 17 байгууллагын орлогын төлөвлөгөө нийт 1,401.4 сая төгрөг гүйцэтгэлээр 1,595.3 сая төгрөг буюу 193.9 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Дээрх байгууллага орлогын төлөвлөгөө биелүүлээгүй буюу 87.1 сая төгрөгөөр тасалсан байна.

Агентлагын үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 17 нэр төрлийн 355.1 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. Нийслэлийн газрын албаны нэг цэгийн үйлчилгээний албан хаагчдын цалинд 180.5 сая төгрөг, НЗДТГ-аас газрын хянан баталгаажуулалтын зардал 1,118.0 сая төгрөг нийт 1,298.5 сая төгрөг нэмэлт санхүүжилтийн дансаар орсноос 1,339.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт харьяалагддаг Говьсүмбэр аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар оруулбал зохих 149 мэдээллийн 44 мэдээллийг хугацаа хоцроосон, Хэнтий аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар 38.6 сая төгрөгийн зарлагын 3 гүйлгээг мэдээлээгүй, 73.6 сая төгрөгийн 7 гүйлгээг хугацаа хоцроосон, 40.0 сая төгрөгийн орлогын 3 гүйлгээг мэдээлээгүй, 269.0 сая төгрөгийн 20 гүйлгээг хугацаа хоцроосон байна. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “shilendans.gov.mn” цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх шаардлагатай байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 14 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 8 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Аудитын явцад ТТЗ-ийн мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, дансны болон ерөнхий журнал, ерөнхий дэвтэр зэрэг хураангуй бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзэж санхүүгийн тайлангийн илэрхийлэлд үнэлэлт өгсөн.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын санхүүгийн тайлан, Нийслэлийн газрын албаны санхүүгийн тайлан болон Агентлагийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Аудитад хамрагдсан нийт 23 салбар, нэгжийн 19 байгууллагад “Зөрчилгүй”, 1 байгууллагад “Хязгаарлалттай”, 1 байгууллагад “Сөрөг” дүгнэлт өгч, 2 байгууллага аудитын түүвэрт хамрагдсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал

Д/д	Байгууллагын нэр	Түүвэрт	Хязгаарлалттай	Сөрөг
1	Говь-Алтай		+	
2	Говь-сүмбэр			+
3	Орхон	+		
4	Агентлаг	+		
НИЙТ		2	1	1



2.9.1 Аудитын санал дүгнэлтийн талаар

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2017 оны санхүүгийн тайланд нэгтгэгдсэн “Говь-Алтай” аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, “Говьсүмбэр” аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар “Сөрөг”, “Хязгаарлалттай” дүгнэлт авсан байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д “... санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай, сөрөг санал, дүгнэлт авсан, ... албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.1-д “төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх” гэж заасны дагуу холбогдох удирдах болон гүйцэтгэх албан тушаалтанд хариуцлага тооцох талаар Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын удирдлагад албан шаардлага өгөх,

2.9.2 Түүвэрт хамрагдсан, Зөрчилгүй, Хязгаарлалттай, Сөрөг санал дүгнэлт авсан байгууллагад илэрсэн зөрчлийн талаар

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан нэр бүхий 22 байгууллагад 510.1 сая төгрөгийн 47 алдаа зөрчил илэрсэн байна. Үүнээс 165.3 сая төгрөгийн 11 залруулга, 2.0 сая төгрөгийн 6 төлбөрийн акт, 70.5 сая төгрөгийн 7 албан шаардлага, 272.3 сая төгрөгийн 23 зөвлөмж өгсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын нэгтгэсэн санхүүгийн тайланд хамрагдсан байгууллагуудад илэрсэн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох арга хэмжээ авах, Төрийн аудитын байгууллагаас өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлж, дотоод хяналтыг сайжруулж ажиллах талаар зөвлөмж өгөх.

2.9.3 Бараа материалын талаар


- Тус байгууллагын мал амьтад данс бүртгэлд нийт 3.3 сая төгрөгийн дансны үнэ бүхий 371 толгой мал бүртгэлтэй байна.
- Тус байгууллагын даргын 2017 оны Б/196 дугаар тушаалаар онд орохгүй 0.4 сая төгрөгийн 23 толгой малыг үнэ төлбөргүй олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Малын анхны өртгийг бодитоор тооцож, данс бүртгэлд тусгаж байх, Онд орохгүй малыг өмч хамгаалах комиссоор шийдвэрлэж байх талаар зөвлөмж өгөх.

2.9.3 Мөнгөн хөрөнгийн талаар

- Тус байгууллагын даргын 2017 оны Б/47, Б/133 дугаартай тушаал нь Хөдөлмөрийн дотоод журмын дагуу 8.5.3-т заасантай нийцэхгүй, мөн 2017 оны А/303 дугаар тушаалаар 10.5 сая төгрөгийг зарцуулах тухай гарсан. Үүнээс “Эйч эс эн” ХХК-тай 2017 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 2017/126 дугаартай 9.5 сая төгрөгийн гэрээ хийсэн боловч санхүүжилтийг бүрэн олгосон,
- Гадаад болон дотоод томилолтоор ажиллах тухай тус байгууллагын даргын 2017 оны А/205, Б/187 дугаар тушаал гарсан байна. Нийт 30.1 сая төгрөгийг урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн боловч 2018 оны 1 дүгээр сард кассанд орлогоор орсон,
- Харилцахаас 9.7 сая төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу байна. Мөн гадаад томилолтын зардал алдаатай, онгоцны билетийн үнийг касснаас бэлнээр авсан,
- Шинэ жил, хүүхдийн баярын бэлгэнд нийт 6.2 сая төгрөгийн зардал гаргасан зэрэг алдаа зөрчлүүд байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар



зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Улсын Их Хурлын 2016 оны 47 дугаар тогтоолын 2-в-5-д “төсвийн хөрөнгөөр шууд болон шууд бус хэлбэрээр шинэ жил, баяр ёслолын аливаа арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, Улсын Их Хурлын 2016 оны 47 дугаар тогтоолыг тус тус мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөх.

2.9.5 Үндсэн хөрөнгийн талаар

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 567 дугаар тогтоолоор “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй барилгын материалын төв лабораторийн тоног төхөөрөмж, эд хогшилыг Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газарт балансаас балансад шилжүүлэхийг үүрэг болгосон боловч чиг үүрэг нь шилжээгүй шалтгаанаар хэрэгжээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2-т “улсын төсвөөс олгосон хөрөнгийг Төсвийн тухай хуульд заасны дагуу зарцуулж, тайлагнах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 567 дугаар тогтоолын дагуу холбогдох арга хэмжээ авч ажиллах талаар зөвлөмж өгөх.

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Говьсүмбэр аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь тайлант хугацаанд арилжааны банкинд бүртгэлтэй мөнгөн кассын дансанд хууль тогтоомж зөрчин 74.6 сая төгрөгийн хууль бус орлого төвлөрүүлэн, зориулалт бусаар зарцуулж, зарлагын гүйлгээ хийсэн байна.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2017 оны А/306 дугаартай тушаалаар 19 нэр төрлийн 18.5 сая төгрөгийн бараа материалыг актласан байна.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад цалингийн бодолт, цагийн бүртгэлийг гүйцээж мөшгин шалгаж тулган баталгаажуулж амжаагүй болно.

Мөн тус газрын 2018 оны 1/246 дугаартай албан бичгээр 17 нэр төрлийн 355.1 сая төгрөгийн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг актлуулах саналыг Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн байна.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 405.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх талаар удирдлагын анхааралд хандуулж 405.0 сая төгрөгийн 4 зөвлөмж, 1 албан шаардлага өгсөн болно.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.



2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Материаллаг байдлын түвшингийн суурийг тус байгууллагын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 2 хувиар тооцож 666.0 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

2.16 АУДИТААР ТООЦСОН ҮР ӨГӨӨЖ

Аудитаар бараа материал, мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгийн дансад горим, нарийвчилсан сорил хэрэгжүүлж, аудитын зөвлөмжийг менежментийн захидлаар өгсөн болно.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар нь аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласнаар 100-500 сая хүртэлх төгрөгийн үр өгөөж бий болно гэж тооцлоо.



3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



3.1 АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан нэр бүхий 22 байгууллагад 510.1 сая төгрөгийн 47 алдаа зөрчил илэрсэн байна. Үүнээс 165.3 сая төгрөгийн 11 залруулга, 2.0 сая төгрөгийн 6 төлбөрийн акт, 70.5 сая төгрөгийн 7 албан шаардлага, 272.3 сая төгрөгийн 23 зөвлөмж өгсөн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хуулийг тус тус зөрчсөн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын нэгтгэсэн санхүүгийн тайланд хамрагдсан байгууллагуудад илэрсэн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох арга хэмжээ авах, Төрийн аудитын байгууллагаас өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах, дотоод хяналтыг сайжруулж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан үнэн зөв байх, эрх үүрэг батламжийн мэдэгдлүүд зөрчигдөх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



3.2 БАРАА МАТЕРИАЛЫН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

- Тус байгууллагын мал амьтад данс бүртгэлд нийт 3.3 сая төгрөгийн дансны үнэ бүхий 371 толгой мал бүртгэлтэй байна.
- Тус байгууллагын даргын 2017 оны Б/196 дугаар тушаалаар онд орохгүй 0.4 сая төгрөгийн 23 толгой малыг үнэ төлбөргүй олгосон байна.

Энэ нь НББОУС 2-т заасантай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Малын анхны өртгийг бодитоор тооцож, данс бүртгэлд тусгаж байх, Онд орохгүй малыг өмч хамгаалах комиссоор шийдвэрлэж байх,


Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Эрсдэлүүд

Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгө, бараа материал, мөнгөн хөрөнгө, санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх, ашиглал шамшигдал үүсэх,

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, төсвийн ажиглалтанд танилцуулсан болно.



3.3 МӨНГӨН ХӨРӨНГИЙН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №3

ҮАГ-ын ажиглалт

- Тус байгууллагын 2017 оны Б/47, Б/133 дугаартай тушаал нь Хөдөлмөрийн дотоод журмын дагуу 8.5.3-т заасантай нийцэхгүй байна.
- Тус байгууллагын даргын 2017 оны А/303 дугаар тушаалаар 10.5 сая төгрөгийг зарцуулах тухай гарсан. Үүнээс “Эйч эс эн” ХХК-тай 2017 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 2017/126 дугаартай 9.5 сая төгрөгийн гэрээ хийсэн боловч санхүүжилтийг бүрэн олгосон,
- Гадаад болон дотоод томилолтоор ажиллах тухай тус байгууллагын даргын 2017 оны А/205, Б/187 дугаар тушаал гарсан байна. Нийт 30.1 сая төгрөгийг урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн боловч 2018 оны 1 дүгээр сард кассанд орлогоор орсон,
- Харилцахаас 9.7 сая төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу байна. Мөн гадаад томилолтын зардал алдаатай, онгоцны билетийн үнийг касснаас бэлнээр авсан,
- Шинэ жил, хүүхдийн баярын бэлгэнд нийт 6.2 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Улсын Их Хурлын 2016 оны 47 дугаар тогтоолын 2-в-5-д “төсвийн хөрөнгөөр шууд болон шууд бус хэлбэрээр шинэ жил, баяр ёслолын аливаа арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг мөрдөж ажиллах

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэж заасныг мөрдөж ажиллах.

Улсын их хурлын 2016 оны 47 дугаар тогтоолын 2-в-5-д “төсвийн хөрөнгөөр шууд болон шууд бус хэлбэрээр шинэ жил, баяр ёслолын аливаа арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх” гэж заасныг мөрдөж ажиллах.


Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Эрсдэлүүд

Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгө дутагдах, ашиглал шамшигдал үүсэх, бүртгэлээр тавих дотоод хяналт алдагдах,

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



3.4 Үндсэн хөрөнгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №4

ҮАГ-ын ажиглалт

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 567 дугаар тогтоолоор “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй барилгын материалын төв лабораторийн тоног төхөөрөмж, эд хогшилыг Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газарт балансаас балансад шилжүүлэхийг үүрэг болгосон боловч чиг үүрэг нь шилжээгүй шалтгаанаар хэрэгжээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2-т “улсын төсвөөс олгосон хөрөнгийг Төсвийн тухай хуульд заасны дагуу зарцуулж, тайлагнах” гэж заасантай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 567 дугаар тогтоолын дагуу холбогдох арга хэмжээ авч ажиллах.


Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Эрсдэлүүд

Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгө дутагдах, ашиглал шамшигдал үүсэх, бүртгэлээр тавих дотоод хяналт алдагдах

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Тодруулга	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,408,288.83	1,892,061.83
МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	155,640.89	497,655.75
АВЛАГА	5а, 5б, 5в, 6а, 6б	322,188.34	161,316.12
УРЬДЧИЛГАА	7а, 7б	16,346.20	75,569.61
БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в,	914,087.71	1,157,494.65
НӨӨЦИЙН БАРАА	9а	25.70	25.70
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		17,476,201.60	16,287,276.43
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в,	17,476,201.60	16,287,276.43
Биет хөрөнгө		8,918,006.38	10,638,117.83
Биет бус хөрөнгө	13	8,558,195.22	5,649,158.61
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		18,884,490.44	18,179,338.27
НИЙТ ӨР ТӨЛБӨР		339,426.48	291,208.06
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	339,426.48	291,208.06
Өглөг	17а, 17б	75,773.09	5,716.07
Урьдчилж орсон орлого	18а, 18б	263,653.39	285,491.98
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		18,545,063.96	17,888,130.21
Засгийн газрын хувь оролцоо		7,542,374.29	17,888,130.21
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		7,542,374.29	7,542,374.29
Хуримтлагдсан үр дүн		10,736,895.50	10,111,241.25
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		265,794.16	234,514.67
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		18,884,490.44	18,179,338.27

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

4.2 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Тодруулга	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		27,703,879.01	32,678,779.86
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	14,123,358.04	4,724,486.91
Нийтлэг татварын бус орлого		14,123,358.04	4,724,486.91
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		11,538,567.30	27,954,292.96
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	18,551,361.00	33,300,004.70
УРСГАЛ ЗАРДАЛ		18,551,361.00	33,300,004.70
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		12,341,859.85	26,947,194.65
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил		5,119,836.50	5,993,573.51
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		576,181.87	664,173.12
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		482,852.43	491,970.72
Хангамж, бараа материалын зардал		728,947.23	812,401.71
Нормативт зардал		3,337.12	6,781.10
Эд хогшил, урсгал засварын зардал		58,258.65	194,006.79
Томилолт, зочны зардал		76,786.22	118,340.29
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		2,316,092.35	13,491,893.33
Бараа үйлчилгээний бусад зардал		2,979,567.49	5,174,054.08
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		4,167,547.47	6,352,810.04
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН		9,152,518.02	-621,224.83
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		-	120.68
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		242,954.24	39,810.17
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН		8,909,563.78	-660,914.33

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

4.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2016 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	9,637,073.62	-	9,637,073.62
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(1,032,397.72)	-	(1,032,397.72)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,827,331.73	-	1,827,331.73
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,043,963.27	-	1,043,963.27
Тайлант үеийн үр дүн	8,909,563.78	-	8,909,563.78
2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	18,545,063.96	-	18,545,063.96
2017 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	18,545,063.96	-	18,545,063.96
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	35,260.07	-	35,260.07
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	18,580,324.03	-	18,580,324.03
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	31,279.49	-	31,279.49
Тайлант үеийн үр дүн	(660,914.33)	-	(660,914.33)
2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	17,888,130.21	-	17,888,130.21

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
(I) ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	17,528,170.65	29,612,657.86
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,429,832.86	2,700,707.24
Нийтлэг татварын бус орлого	3,429,832.86	2,700,707.24
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	12,272,534.83	26,911,950.61
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	16,895,436.26	27,459,252.22
УРСГАЛ ЗАРДАЛ	16,895,436.26	27,459,252.22
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,434,961.31	22,870,680.30
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	5,105,782.89	6,107,920.24
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	561,362.76	624,058.94
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	414,550.51	414,170.82
Хангамж, бараа материалын зардал	315,853.22	437,673.17
Нормативт зардал	19,501.94	13,995.41
Эд хогшил, урсгал засварын зардал	89,126.10	190,063.60
Томилолт, зочны зардал	89,886.18	176,124.44
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,939,303.87	14,229,137.35
Бараа үйлчилгээний бусад зардал	899,593.84	677,536.33
ТАТААС	1,115,873.35	-
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,344,601.60	4,588,571.92
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	632,734.39	2,153,405.64
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	480,055.09	1,811,390.77
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	480,055.09	1,811,390.77
Дотоод эх үүсвэрээр	480,055.09	1,811,390.77
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(40,055.09)	(1,811,390.77)
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	152,679.30	342,014.87
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,961.59	155,640.89
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	155,640.89	497,655.75



4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,073,078.60	10,043,339.84	29,738.76	99.70
УРСГАЛ ЗАРДАЛ	10,073,078.60	10,043,339.84	29,738.76	99.70
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,589,064.80	9,584,990.65	4,074.15	99.96
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	5,764,898.60	5,825,761.15	-60,862.55	101.06
Үндсэн цалин	3,977,022.14	4,070,393.99	-93,371.85	102.35
Нэмэгдэл цалин	1,141,756.76	1,115,012.47	26,744.29	97.66
Унаа хоолны Хөнгөлөлт	242,146.26	235,505.33	6,640.93	97.26
Урамшуулал	24,493.80	26,039.48	-1,545.68	106.31
Гэрээт ажлын цалин	379,479.64	378,809.88	669.76	99.82
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	632,546.00	612,682.39	19,863.61	96.86
Тэтгэврийн даатгал	491,771.23	537,835.55	-46,064.32	109.37
Тэтгэмжийн даатгал	34,150.92	15,469.89	18,681.03	45.30
ҮОМШӨ-ний даатгал	29,198.30	16,633.45	12,564.85	56.97
Ажилгүйдлийн даатгал	7,038.21	5,233.28	1,804.94	74.36
Эрүүл мэндийн даатгал	70,387.34	37,510.22	32,877.11	53.29
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	429,968.00	412,094.61	17,873.39	95.84
Гэрэл, цахилгаан	37,248.10	34,748.93	2,499.17	93.29
Түлш, халаалт	239,679.00	223,915.66	15,763.34	93.42
Цэвэр, бохир ус	30,279.50	24,728.41	5,551.09	81.67
Байрны түрээс	122,761.40	128,701.61	-5,940.21	104.84
Хангамж, бараа материалын зардал	272,082.60	310,946.00	-38,863.40	114.28
Бичиг хэрэг	47,970.50	55,429.25	-7,458.75	115.55
Тээвэр, шатахуун	133,999.50	160,497.53	-26,498.03	119.77
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	41,567.30	42,091.63	-524.33	101.26
Ном, хэвлэл	820.00	1,715.00	-895.00	209.15
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	716.50	438.50	278.00	61.20
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	47,008.80	50,774.09	-3,765.29	108.01
Нормативт зардал	7,741.80	7,571.39	170.41	97.80
Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,741.80	7,571.39	170.41	97.80
Эд хогшил, урсгал засварын зардал	49,575.60	111,736.80	-62,161.20	225.39
Багаж, техник, хэрэгсэл	16,105.50	40,444.09	-24,338.59	251.12
Тавилга	0.00	269.00	-269.00	-
Урсгал засвар	33,470.10	71,023.71	-37,553.61	212.20
Томилолт, зочны зардал	53,811.30	62,991.51	-9,180.21	117.06
Дотоод албан томилолт	53,811.30	62,991.51	-9,180.21	117.06
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,848,227.90	1,795,059.05	53,168.85	97.12
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,332,151.00	1,321,687.85	10,463.15	99.21
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,272.40	2,320.10	952.30	70.90
Даатгалын үйлчилгээ	13,201.40	12,919.26	282.14	97.86
Тээврийн хэрэгслийн татвар	3,778.10	3,425.54	352.56	90.67
Тээврийн хэрэгслийн оношилгоо	1,250.90	1,197.45	53.45	95.73
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	34,665.50	33,213.91	1,451.59	95.81
Газрын төлбөр	147.50	158.46	-10.96	107.43

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	721.70	400.00	321.70	55.42
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	459,039.40	419,736.49	39,302.91	91.44
Бараа үйлчилгээний бусад зардал	530,213.00	446,147.75	84,065.25	84.15
Бараа үйлчилгээний бусад зардал	527,857.30	442,724.31	85,132.99	83.87
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,355.70	3,423.44	-1,067.74	145.33
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,911.10	1,906.02	5.08	99.73
Засгийн газрын гадаад шилжүүлэг	1,911.10	1,906.02	5.08	99.73
Бусад урсгал шилжүүлэг	482,102.70	456,443.16	25,659.54	94.68
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	123,529.20	123,390.07	139.13	99.89
Төрөөс иргэдэд үзүүлэх бусад тэтгэмж, урамшуулал	9,413.80	7,913.75	1,500.05	84.07
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	171,358.60	148,144.21	23,214.39	86.45
Нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшуулал	177,801.10	176,995.13	805.97	99.55
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	10,073,078.60	10,043,609.61	29,468.99	99.71
Улсын төсвөөс санхүүжих	10,073,078.60	10,043,609.61	29,468.99	99.71
Улсын төсвөөс санхүүжих	2,753,686.00	2,749,658.78	4,027.22	99.85
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	7,319,392.60	7,293,950.82	25,441.78	99.65
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	53,350.75		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	457,240.07		
БАЙГУУЛЛАГЫН ТОО	23.00	23.00		
АЖИЛЛАГСАД БҮГД	559.00	617.00		
Удирдах ажилтан	25.00	26.00		
Гүйцэтгэх ажилтан	443.00	497.00		
Үйлчлэх ажилтан	91.00	91.00		
Гэрээт ажилтан	-	3.00		



5 Зөрчлийн нэгтгэл

Хавсралт 1

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2017 он	Аудитын код:	САГ-2018/14/СТА-ТТ3	Сая төгрөгөөр
Аудитын нэр:	Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудит			
Шалгагдсан байгууллагын нэр:	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар			

№	Аудитын зорилт, чиглэл	Тоо	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
					Нэр	Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5	6	7
1	Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудит		Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2017 оны санхүүгийн тайланд нэгтгэгдсэн Говь-Алтай аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар "Хязгаарлалттай", Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар "Сөрөг", дүгнэлт авсан байна.	-	Албан шаардлага Албан шаардлага	1.Говь-Алтай аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга, 2.Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга,	М.Ууган-Эрдэнэ Д.Тамир

